

Зургаа. Стратегийн зорилго

Бүс нутгийн соёлын онцлог байдал дээр тулгуурласан нэгдмэл үнэт зүйл, ард түмний ялгаатай өв соёлыг хадгалж, хамгаалах, түгээн дэлгэрүүлж, сурталчлах, нутаг орны бахархал брендийг бий болгох замаар бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, соёлын тогтвортой хөгжлийг хангахад оршино.

Энэхүү стратегийн зорилгын хүрээнд хүрэх үр дүнг дараах зорилтуудаар 2021-2024 онд хэрэгжүүлэхээр тодорхойлов. Үүнд:

Стратегийн зорилт-1. Соёлын өвийг хамгаалах, сурталчилах

- Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай хуулийг сурталчилж, хэрэгжилтийг хангана.

Стратегийн зорилт-2. Соёлын өвийн мэдээлийн санг нэмэгдүүлэх

- Соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх

Стратегийн зорилт-3 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх дунд хугацааны бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх.

- Үндэсний агуулга бүхий оюуны өмчийн эрхтэй үндэсний бренд соёл, урлаг, урлалын бүтээлийн шинэ санаа, санаачлагыг хөхүүлэн дэмжиж, түүнд түшиглэсэн соёлын бүтээлч ажлын зохион байгуулах.
- Соёлын аялал жуулчлалын хүрээнд аялагчдад зориулсан соёл урлагийн мэргэжлийн байгууллагуудын бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- “Баруун бүсийн соёлын аялал жуулчлалын зөвлөгөөн-2023”

Стратегийн зорилт-4 Салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж тайлагнах

- **Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон**
- Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангах.

Стратегийн зорилт-5 Түүх, уламжлал, өв соёл, зан заншил, соёл, урлагийн бүтээлийг хөгжүүлэн, тогтвортой хөгжлийг хангаж, сурталчилна.

- Түүх, соёлын үнэ цэнэтэй дурсгал, дурсгалт газрыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаална.
- Бүс нутгийн ард түмний биет бус соёлын өвийг хадгалж хамгаалах, хөгжүүлэх ЗДҮАХ-ийн 2.6.1.4 зорилтын хүрээнд “Алтайн нүүдэлчдийн баяр” арга хэмжээ

- “Анчин бүргэд-” өв эрдэнийг хөгжүүлж, соёлын хүрээг олон улсын арга хэмжээ руу өргөжүүлэх.
- Соёл, урлагийн салбарт хэрэгжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах

Стратегийн зорилт 6. Нутаг дэвсгэрийн соёлын онцлогийг хадгалж, хөгжүүлсэн тогтвортой хөгжлийн чиг хандлагатай болох

- “Монголын казахуудын өв соёлын их наадам” биет бус соёлын өвийг сурталчлан таниулах.
- “Цаст Алтайн дуулал” баруун бүсийн язгуур урлагийн их наадам

Стратегийн зорилт 7. Соёлын салбарын үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах.

- Өрсөлдөх чадвар бүхий бүс нутгийн соёл, урлагийн салбарын хүний нөөц бүрдүүлэх
- Соёл, урлагийн салбарын хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Хөгжимт драмын театрын их засвар хийнэ.
- Аймгийн нийтийн номын сангийн Lib-4U программыг шинэчилж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- Кино үзвэрийн үйлчилгээ бий болгох

Стратегийн зорилт 8. Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

- Харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

Стратегийн зорилт 9. Хүний нөөц, төсөв, санхүү, технологийн болон бусад нөөцийг үр ашигтай удирдах

- Өрсөлдөх чадвар бүхий соёл, урлагийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, ажлын байраар хангах тогтолцоог
- Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх тайлагнах

Стратегийн зорилт 10. Харьяа байгууллагуудын албан хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

- Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэн ажиллах

**Тайлагналт төлөвлөлт мэдээлэл технологи цахимжуулалтын асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Еркеш
Утас: 70422289, 95157557**